



ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2025 оны 11 сарын 20 өдөр

Дугаар А/44

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Шадар Сайдын 2023 оны 28 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/160, А/161 дүгээр тушаалууд, 2018 оны А/527 дугаар тушаал, Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн дүрмийн 8.2, 8.3 8.4, 8.5, 8.6, 8.7, 8.8 дахь заалтууд, Удирдлагын зөвлөлийн 2025 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 13 дугаар хурлын шийдвэрийг тус тус ТУШААХ нь:

1. Зоонозын шалтгаант өвчний сэжигтэй дуудлагад үйлчлэх журмыг нэгдүгээр хавсралтаар, Лабораторийн шинжилгээнд сорьц цуглуулах иж бүрдлийг хоёрдугаар, мэрэгч, амьтны дуудлагын хайрцагт байх эд зүйлсийн жагсаалтыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тушаалыг холбогдох эмч, мэргэжилтнүүдэд танилцуулж, өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдүүлэн ажиллахыг Нийгмийн эрүүл мэнд, тандалт, шуурхай удирдлагын албаны дарга (Х.Ариунболд), Лавлагаа Лабораторийн албаны дарга (У.Өнөрсайхан) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалыг хэрэгжүүлэхэд шаардлагатай нөөцийн хангалт хийж, дэмжлэг үзүүлж ажиллахыг Санхүү, хангамж нөөцийн албаны Ерөнхий нягтлан бодогч (Д.Болормаа)-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Чанар, аюулгүй байдал, хяналт үнэлгээний албаны дарга (Б.Ичинхорол)-д даалгасугай.

5. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан төвийн захирлын 2018 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн А/59, 2020 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн А/93, 2021 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн А/60 дугаар тушаалуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.АМГАЛАНБАЯР

[illegible][illegible][illegible]

આચાર્ય શ્રીમદ્ભગવાદ ગીતા

2021 10/6 11 12/20 100

தேதி 3/10

[illegible]

୨୫) ଯେ ଲାଗୁଣ ଯେ ୨୫/୧୧/୧୯
 ୨୬) ଯେ ୧୫/୧୧/୧୯ ଯେ ୧୫/୧୧/୧୯

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн
Захирлын албан үүргийг хавсран гүйцэтгэгчийн
2025 оны 11 дугаар сарын 20-ний өдрийн
А/44 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

ЗООНОЗЫН ШАЛТГААНТ ӨВЧНИЙ СЭЖИГТЭЙ ДУУДЛАГАД ҮЙЛЧЛЭХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

Зоонозын шалтгаант өвчний сэжигтэй дуудлага хүлээн авах, бүртгэх, мэдээлэх, хариу арга хэмжээ зохион байгуулах, бэлэн байдлыг хангах үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

1.1 Дуудлагын тусламж үйлчилгээнд ажиллах баг бүрэлдэхүүний нэрс, хуваарийг бүх албадууд жил бүрийн 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор Нийгмийн эрүүл мэнд, тандалт, шуурхай удирдлагын албанд хүргүүлэх ба тус алба сар бүр томилгоот хуваарийг гарган төвийн захирлаар батлуулна.

1.2 Дуудлагын тусламж үйлчилгээний баг бүрэлдэхүүн "Халдварын сэргийлэлт, хяналт, био-аюулгүй ажиллагааны дэглэм"-ийн зааврыг баримтлан ажиллана.

1.3 Дуудлагын тусламж үйлчилгээний багт халдвар судлагч, эмнэлзүйч, лабораторийн эмч (нян судлаач, вируслогич), биологич (амьтан судлаач, паразитологич), генетикч, лаборант, ариутгагч, био-бэлдмэлчин, түргэн тусламжийн жолооч нар тус тус ажиллана.

1.4 Дуудлагын тусламж үйлчилгээний багийн гишүүн нь хүндэтгэн үзэх шалтгааны улмаас дуудлагад үйлчлэх боломжгүй болсон тохиолдолд харьяалах албаны дарга, дуудлага хяналтын бага эмчид урьдчилан мэдэгдэж дараа сарын дуудлагын багийн гишүүн үйлчлэх зохицуулалт хийлгэнэ.

1.5 Дуудлагын тусламж үйлчилгээний багийн гишүүд нь тухайн үеийн нөхцөл байдлаас хамаарч Мэргэжлийн баг болон Чанарын менежерийн хамт сарын дуудлагын багийн мэдээлэл, ирүүлсэн сорьц, лабораторийн шинжилгээний талаар хэлэлцэх ба дуудлага бага үед 14 хоногт 1 удаа цугларч дуудлагын үйл явцын мэдээлэл солилцоно.

1.6 Дуудлагын бэлэн байдлыг алдагдуулахгүйн тулд тухайн дуудлагын сарын түргэн тусламжийн жолооч болон тээврийн хэрэгслэлийг бусад үйлчилгээнд явуулахгүй байж бэлэн байдлыг хангана.

1.7 Дуудлагын тусламж үйлчилгээний багийн гишүүд нь байгууллагын болон бусад хувь хүний нууцыг хадгална.

1.8 Дуудлагын тусламж үйлчилгээний багийн гишүүд төвийн захирлын 2025 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн А/58 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "ЗӨСҮТ, ЗӨСТ-ийн үйл ажиллагаанд хөтлөгдөх анхан шатны бүртгэл маягт"-ыг мэргэжлийн чиг үүрэг тус бүрийн дагуу хөтөлнө.

1.9 Зоонозын шалтгаант хүний өвчлөлийн дуудлагын үед Эрүүл мэндийн сайдын 2017 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн А/160 дугаар тушаалын

хавсралтад заасан зоонозын халдварт өвчний тархвар судалгааны хуудсыг хөтөлнө.

Хоёр. Үйлчлэх хүрээ

2.1. Дуудлагын тусламж үйлчилгээний баг нь батлагдсан хуваарийн дагуу тухайн сард бүртгэгдсэн зоонозын хүний өвчний болон мэрэгч, амьтны сэжигтэй дуудлагад хариу арга хэмжээг цаг алдалгүй түргэн шуурхай үйлчилж мэргэжил арга зүйгээр хангана.

2.2. Мэрэгч, амьтны сэжигтэй дуудлагад Зоонозын өвчин судлалын үндэсний төв нь төвийн 6 дүүрэгт (Хан-Уул, Сонгинохайрхан, Баянгол, Баянзүрх, Чингэлтэй, Сүхбаатар), Нийслэлийн Зоонозын өвчин судлалын төв нь алслагдсан 3 дүүрэгт (Налайх, Багануур, Багахангай) хариу арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлнэ.

2.3. Нийслэл хот орчимд бүртгэгдсэн зоонозын шалтгаант хүний өвчлөлийн дуудлагад "Халдварт өвчин судлалын үндэсний төв"-ийн яаралтай тусламжийн баг эмнэлзүйн урьдчилсан онош тавьж, тус төвд дуудлага өгснөөр Нийслэлийн болон Үндэсний төвийн тусламж үйлчилгээний баг үйлчилж хариу арга хэмжээг зохион байгуулна.

Гурав. Дуудлага хүлээн авах, бүртгэх, мэдээлэх

3.1 Дуудлага хяналтын бага эмч нь 70282853 дугаарын суурин утсаар 24/7 цагаар дуудлага, мэдээлэл хүлээн авч бүртгэснээс хойш 05 минутын дотор дуудлагын тусламж үйлчилгээний багийн ахлагч, гишүүдэд, шаардлагатай тохиолдолд 20 минутын дотор албаны дарга нар, төвийн захиралд урьдчилан утсаар мэдэгдэж, төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем өгр цахим харилцааны модулиар мөн мэдээлнэ.

3.2 Нийтээр амрах баяр, амралтын өдрүүдийг үл харгалзан дуудлагын тусламж үйлчилгээний багийн гишүүд нь холбоо барих утсаа байнга нээлттэй байлгана. Ажлын цагаар хүлээн авсан дуудлагын үед 30 минут, ажлын бус цагт 1-2 цагийн дотор дуудлагад гарсан байна.

3.3 Дуудлагын тусламж үйлчилгээний баг нь хүлээн авсан дуудлагын нөхцөл байдалд үнэлгээ өгөх, зоонозын холбогдолтой эсэхийг нягталж, зөвлөх, эргэн мэдээлэх асуудлыг хариуцан гүйцэтгэж, шаардлагатай тохиолдолд дуудлагад очиж үйлчилнэ.

3.4 Дуудлага хяналтын бага эмч нь Зоонозын хүний өвчлөлийн сэжигтэй дуудлагыг хүлээн авч бүртгэсний дараа тархвар судалгааны хуудсын дагуу бүрэн бөглөж, дуудлагын тусламж үйлчилгээний багийн ахлагчид өгөх ба голомтод хэрэгжүүлж буй арга хэмжээ, нөхцөл байдлын мэдээ, үйлчлүүлэгчийн биеийн байдал, шинжилгээний явцын мэдээллийг аймаг, нийслэлийн ЗӨСТ, ЭМГ болон бусад холбогдох байгууллагаас 2 цаг тутам авч дуудлагын тусламж үйлчилгээний багийн бүрэлдэхүүнд мэдээлнэ.

3.5 Зоонозын хүний өвчлөлийн сэжигтэй дуудлагыг ЭМЯ-ны холбогдох газар, хэлтэст мэдээлэх асуудлыг албаны дарга, төвийн захирлын шийдвэрээр шуурхай удирдлагын нэгжийн мэргэжилтэн мэдээлнэ.

3.6 Дуудлага хяналтын бага эмч нь жижүүрийн хугацаан дах хоногийн товч мэдээллийг албаны даргад танилцуулна.

3.7 Лабораторийн эмч шинжилгээний явцын болон эцсийн хариуг зоонозын өвчний сэжигтэй тохиолдлын мэдээлэх хуудсанд тэмдэглэж, баталгаат шинжилгээний хариуг төвийн цахим хаягаар холбогдох байгууллага, эмч, мэргэжилтнүүдэд шуурхай хүргүүлнэ.

3.8 Шаардлагатай тохиолдолд халдвар хариуцсан мэргэлжийн баг нь сарын дуудлагын тусламж үйлчилгээний багт холбогдох мэдээллийг бэлтгэж өгөх, эрсдэлийн явцын болон түргэвчилсэн үнэлгээг хамтарч хийж, зөвлөгөө, зөвлөмж өгч ажиллана.

3.9 Биостатистикч өдөр бүр дуудлага хяналтын бага эмчээс дуудлагын мэдээг авч нэгтгэн, дуудлагын мэдээний үнэн зөв бодит байдалд хяналт тавьж, дүгнэлт хийнэ.

Дөрөв. Зоонозын шалтгаант хүний өвчлөлийн дуудлага

4.1 Дуудлагын тусламж үйлчилгээний багийн гишүүд хүлээн авсан дуудлагын цар хүрээг тодорхойлж, цаг үеийн байдлыг үндэслэн шуурхай удирдлагын нэгж, халдвар хариуцсан багийн гишүүдтэй хамтран эрсдэлийн үнэлгээ хийж, хариу арга хэмжээг яаралтай зохион байгуулна.

4.2 Зоонозын хүний өвчлөл дэгдэлт хэлбэрээр гарч тархвар судлалын нөхцөл байдал хүндэрсэн, эрсдэл "Дунд"-аас дээш үнэлэгдсэн тохиолдолд нэмэлтээр томилгоожуулах баг бүрэлдэхүүнийг төвийн тохиолдлын удирдлагын тогтолцоо хариуцсан дарга шийдвэрлэнэ.

4.3 Монгол Улсын Шадар сайдын тушаалын дагуу тохиолдлын удирдлагын тогтолцоо идэвхжлийн зэргийг тогтоон тушаал төлөвлөж, тохиолдлын удирдлагын тогтолцооны зарчмаар ажиллана.

4.4 Дуудлагын тусламж үйлчилгээний багийн халдвар судлагч нь зоонозын өвчний сэжигтэй онош тодруулахаар ирүүлсэн сорьц, халдвартай ба сэжигтэй материалыг сарын дуудлагын багийн лабораторийн эмч, лаборант нарт хүлээлгэн өгнө.

4.5 Хүний өвчлөлийн дуудлаганд үйлчилсэн хариу арга хэмжээний мэдээллийг зоонозын халдварын хүний өвчний сэжигтэй тохиолдлыг мэдээлэх хуудаст тухай бүр тодорхой бичиж, тэмдэглэсэн байна.

4.6 Лабораторийн эмч шинжилгээний урьдчилсан хариуг тухай бүр тэмдэглэлд тодорхой бичиж, эх хувийг халдвар судлагчид шуурхай мэдээлсэн байна.

4.7 Дуудлагын тусламж үйлчилгээний баг дараа сарын багийн гишүүдэд бэлэн байдлын хайрцагт байх эд зүйлсийн нөхөн хангалт, тухайн сарын дуудлагад шинжлэгдээгүй сорьц материалыг протокол үйлдэж хүлээлцэнэ.

Тав. Мэрэгч, амьтны дуудлага

5.1 Дуудлагын тусламж үйлчилгээний багийн биологич нь дуудлага өгсөн иргэн, албан хаагчаас утсаар холбогдон нэмэлт мэдээллийг авч болно. Үүнд: байршил, амьтны төрөл, тоо ширхэг, нөхцөл байдал гэх мэт.

5.2 Мэрэгч амьтны дуудлагад нэг удаагийн хамгаалах комбинзон эсвэл нимгэн халад, бээлий, амны хаалт, малгай хэрэглэнэ.

5.3 Мэрэгч, амьтны дуудлагад дараах шалгуурын дагуу үйлчилнэ:

5.3.1 Тарваган тахал түүнтэй хам тохиолдох өвчний холбогдол бүхий мэрэгч, туулай хэлбэртэн: (тарвага, зурам, огтоно, хулгана, харх, туулай гэх мэт мэрэгчид).

5.3.2 Галзуу өвчний холбогдол бүхий төрөл зүйл болон шалтгаан нь тодорхойгүй үхсэн, араатан амьтад (үнэг, чоно, хярс, дорго, өмхий хүрэн).

5.3.3 Шувууны томуу өвчний холбогдол бүхий шалтгаан нь тодорхойгүй олон тооны үхсэн зэрлэг шувуудад мэдээллийн дагуу.

5.4 Гэрийн тэжээвэр мал, амьтны (нохой, муур, таван хошуу мал) дуудлагын үед тухайн мал, амьтны эзэд, малчидын эрүүл мэндийн талаар тодруулга авч, холбогдолгүй гэж үзвэл дуудлагыг мал эмнэлгийн байгууллагад мэдээлж, шилжүүлнэ.

5.5 Мэрэгч амьтны (тарвага) дулаан боловсруулалтын аргаар чанаж болгосон мах, (лаазалсан, утсан, чанаж болгосон мах) болон түүний түүхий эд эрхтэнийн дуудлагад үйлчлэхгүй.

5.6 Дуудлагын тусламж үйлчилгээний багийн биологич нь тархвар судлалын холбогдол, тухайн нөхцөл байдлыг харгалзан сорьц материалыг яаралтай шинжлүүлэх асуудлыг багийн ахлагчид мэдээлж шийдвэрлүүлнэ.

5.7 Амьд мэрэгч амьтны дуудлагад үйлчлэх тохиолдолд:

5.7.1 Тухайн амьтныг (тарвага) сайтар ажиглаж, хөдөлгөөний идэвх суларсан, арьс үс нь шархалсан, хачиг, бүүрэгт баригдсан, бэртэж гэмтсэн тохиолдолд амьтан баригч дэгээ, тор ашиглан барьж зовоолгүй хурдан үхүүлнэ.

5.7.2 Жижиг мэрэгч (хулгана, зурам гэх мэт) амьтныг урт хямсаа, хавчаараар багалзуур хэсэгт хавчиж үхүүлсний дараа тээвэрлэнэ.

5.8 Байгальд тарвагыг буцааж эргүүлэн тавих тохиолдолд:

5.8.1 Тухайн газар бүс нутаг нь тарваган тахлын байгалын голомт тэмдэглэгдээгүй, сүүлийн 3-5 жилийн хугацаанд голомт хяналтын шинжилгээнд хамрагдаж, халдвартай материал илрээгүй тохиолдолд.

5.8.2 Гадаад шинж, хөдөлгөөний идэвх хэвийн, тарга тэвээрэг сайн, бэртэл гэмтэлгүй тохиолдолд фото зураг авч баримтжуулж, баригч дэгээ, тор ашиглан барьж тухайн байгальд нь ойролцоо нүхэнд буцааж тавина.

5.9 Ажлын цагаар дуудлагын сорьц материалыг амь сорьцын лабораторид сарын дуудлагын багийн ариутгагчид хүлээлгэн өгөх, харин ажлын бус цагаар дуудлага хяналтын жижүүр эмчийн хяналтад сорьц түр хадгалах хөргөгчид шинжилгээ хийх хүртэл хадгална.

5.10 "Мэрэгч, амьтны дуудлагад үйлчилсэн тэмдэглэл"-ийг (хавсралт 4) дуудлага өгсөн албан байгууллага, төрийн албан хаагч болон иргэнд 1 хувийг өгнө.

5.11 Дуудлагаар авчирсан сорьц материал нь лабораторийн шинжилгээний шаардлага хангахгүй тухайлбал: өмхийрсөн, муудсан, шинжилгээнд түгээмэл авдаггүй эд эрхтэн, илжирч хуучирсан арьс, үс, ноос гэх мэт тохиолдолд ариутгал, халдваргүйжүүлэлт хариуцсан халдвар судлагчийн хяналтад устгуулж, тэмдэглэл хөтлөх ба амьтны дуудлагын бүртгэлд тэмдэглэнэ.

5.12 Дуудлагын тусламж үйлчилгээний багийн халдвар судлагч нь үндэсний төвийн лабораторийн баталгаат шинжилгээний хариуг үндэслэн дүгнэлт гаргах ба биологич нь дуудлага өгсөн иргэнд утсаар, албан байгууллагад албан бичгээр эргэн мэдээлнэ.

5.13 Мэрэгч, амьтан болон түүхий эд тээвэрлэсэн дуудлагын тээврийн хэрэгслэл болон түр зөөвөрлөсөн сав, орчинд халдваргүйжүүлэлт хийнэ.

Зургаа. Дуудлага хяналтын бага эмчийн ажлын чиг үүрэг

6.1 Дуудлага хяналтын бага эмч нь батлагдсан хуваарийн дагуу ажиллана. Ажлын өдөр 8³⁰, амралт, баяр ёслолын өдрүүдэд 9⁰⁰ цагт ажлаа хүлээж авна.

6.2 Төвд ирсэн дуудлага, холбогдох байгууллагууд, иргэдээс тавьсан асуулт, санал хүсэлтийг шуурхай хүлээн авч, удирдлага болон харилцагч байгууллагуудыг үнэн зөв мэдээллээр хангаж, үйлчлүүлэгч, харилцагчдын сэтгэлд нийцсэн үйлчилгээ үзүүлнэ.

6.3 Зоонозын хүний өвчлөлийн лабораторийн баталгаат шинжилгээний хариуг холбогдох газруудад шуурхай хүргэх ажлыг хариуцаж, эргэн мэдээлнэ.

6.4 Яаралтай дуудлагын хүрээнд орон нутгаас ирүүлсэн вакцин, ийлдэс, тэжээлт орчин, оношлуурын захиалгыг хүлээн авсан тухай бүр дархлаажуулалт хариуцсан эмч, сарын дуудлагын багийн ахлагч, түргэн тусламжийн жолоочид мэдэгдэн хүйтэн хэлхээний горимын дагуу зөөвөрлөхөд бэлтгэн орон нутагт хүргүүлэх ажлыг шуурхай шийдвэрлүүлнэ.

6.5 Ажлын бус цагаар орон нутагт яаралтай хүргүүлэх лабораторийн амьтны захиалгыг хүлээн авч амьтан хариуцсан мэргэжилтэнд мэдээлж шийдвэрлүүлнэ.

6.6 Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал үүсч галын аюул, газар хөдлөлт, үер, хүчтэй салхи, шуурга, террорист халдлага, аюулт үзэгдэл, гамшгийн үед байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөний дагуу ажиллана.

6.7 Хүний өвчлөл, амьтны дуудлагын мэдээллийг цахим системд оруулж, сарын дуудлагын багт мэдээлнэ.

Долоо. Дуудлагын тусламж үйлчилгээний багийн гишүүдийн чиг үүрэг

7.1 Халдвар судлагчийн үүрэг:

7.1.1. Багийн ахлагчийн үүрэг гүйцэтгэж хүлээн авсан дуудлагын цар хүрээг тодорхойлж, тархвар судлалын холбогдлыг тогтооно.

7.1.2.Цаг үеийн байдлыг үнэлэн халдвар тархахаас сэргийлэх хариу арга хэмжээг зохион байгуулж, зөвлөгөө, зөвлөмж өгч ажиллана.

7.1.3.Зоонозын шалтгаант өвчний онош тодруулахаар ирүүлсэн сорьц, өсгөвөр, халдвартай ба сэжигтэй материалыг тухайн сарын дуудлагын лабораторийн эмч, лаборант нарт хүлээлгэн өгч, анхан шатны бүртгэл маягтыг хөтөлнө.

7.1.4.Дуудлагад авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай мэдээлэх хуудас дээр тодорхой бичиж тэмдэглэнэ.

7.1.5.Хүний өвчлөлийн дуудлагын сорьц, тархвар судлал, хариу арга хэмжээний мэдээллийн хэсгийг цахим системд оруулна.

7.2 Эмнэлзүйч эмчийн үүрэг:

7.2.1.Зоонозын шалтгаант үйл явдал, дэгдэлтийн үед орон нутгийн мэргэжлийн салбар, бусад эрүүл мэндийн байгууллага, иргэдэд мэргэжил арга зүйн зөвлөгөө, зөвлөмж өгөх, шаардлагатай тохиолдолд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх, дуудлагын багийн гишүүдийн эрүүл мэндийг хянаж, зөвлөгөө өгнө.

7.2.2.Халдварын эрсдэлтэй эд зүйлстэй харьцаж байх үедээ дэглэмийн зөрчил гаргасан гишүүдийг эрүүл мэндийн үзлэгт хамруулах, шаардлагатай тохиолдолд эмнэлэгт хэвтүүлэх, оношийг тодруулах асуудлыг хариуцан ажиллана.

7.2.3.Хүний өвчлөлийн эмнэл зүйн шинж, онош, тавилан, батлагдсан, үгүйсгэгдсэн талаарх мэдээллийг эмнэлзүйч эмч хариуцан цахим системд оруулна.

7.3 Лабораторийн эмч, генетикчийн үүрэг:

7.3.1.Тухайн сарын хүн ба мэрэгчийн дуудлагад үйлчилж байгаа эмч нь лаборантын хамт оношлуур урвалж, тэжээлт орны нөөцийн бэлэн байдлыг ханган ажиллана.

7.3.2.Шинжилгээний техник үйл ажиллагаанд биоаюулгүй ажиллагаа холбогдох журам, шинжилгээний стандарт ажлын зааврыг баримтлан ажиллана.

7.3.3.Онош тодруулах шаардлагатай сорьц материалыг лабораторийн шинжилгээнд хамруулж, баталгаат шинжилгээний хариу гарах хүртлэх хугацаан дах үйл ажиллагааг хариуцна.

7.3.4.Шинжилгээний явцад хөтлөгдөх, анхан шатны бүртгэл маягтыг хөтөлж, шинжилгээний үр дүнг тухай бүрт мэдээлэх хуудсан дээр тодорхой тэмдэглэж, харъяа албаны дарга болон сарын дуудлагын багийн ахлагчид мэдээлнэ.

7.3.5.Лабораторийн баталгаат шинжилгээний хариуг сарын дуудлагын халдвар судлагчид цаасан хэлбэрээр өгч, мэдээллийн цахим системд оруулна.

7.4 Биологчийн үүрэг:

7.4.1.Дуудлага өгсөн газраас халдварын сэжигтэй материалыг очиж авах ба дуудлагад шаардлагатай багаж хэрэгслийн бэлэн байдлыг хангаж ажиллана.

7.4.2.Хураагдсан, ил задгай хаягдсан сорьц материалыг хүлээн авахдаа тоо ширхэг, төрөл, зүйл тээвэрлэж байгаа хүний нэр хаягийг дуудлага өгсөн албан хаагч, иргэнээс авч, тэмдэглэл хөтөлнө.

7.4.3.Дуудлагаар авчирсан сэжигтэй материалыг төвийн амь сорьцийн лабораторит морфологи судалгаанд хамруулан, самналтаар гадны шимэгчийг түүж, амьтны үхлийн шалтгааныг тодруулна.

7.4.4.Цуглуулсан гадны шимэгчийг "Шимэгч судлалын лаборатори"-д тоо ширхэг, зүйлийн бүрдэлийг тодорхойлж, дагалдах бичгийн хамт нян судлалын лабораторид шилжүүлэн шинжилгээнд хамруулна.

7.4.5.Дуудлагад үйлчилсэн явцыг "Мэрэгч амьтны дуудлагын бүртгэл"-д бүртгэж, мэдээллийг цахим системд оруулна.

7.4.6.Анхан шатны болон явцын эрсдэлийн түргэвчилсэн үнэлгээ хийхэд байгалийн голомтын товч мэдээллийг бэлтгэн оролцоно.

7.5 Лаборантийн үүрэг:

7.5.1.Дуудлагын цүнхэд сорьц цуглуулах багцыг жагсаалтын дагуу шалгаж, бэлтгэн яаралтай дуудлагын бэлэн байдлыг хангана.

7.5.2.Шинжилгээний явцад лабораторийн техник үйл ажиллагаанд биоаюулгүй ажиллагаа болон шинжилгээний стандарт ажлын зааврыг баримтлан ажиллана.

7.5.3.Лабораторийн шинжилгээнд сорьц цуглуулах, анхан шатны бүртгэл маягтыг хөтлөнө.

7.6 Ариутгагч, бэлдмэлчийн үүрэг:

7.6.1.Зоонозын шалтгаант өвчний дуудлаганд үйлчилж, сэжигтэй материал тээвэрлэсэн тээврийн хэрэгслэл, хадгалж байсан ойр орчмын талбайг халдваргүйтгэнэ.

7.6.2.Ариутгал, халдваргүйтгэлд хэрэглэх бодис, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, сав суулга, эд, аж ахуйн хэрэгслийн бэлэн байдлыг хангана.

7.6.3.Амь сорьцын лабораторийн цэвэрлэгээ болон халдварын сэжигтэй материалыг халдваргүйжүүлэх, устгах, хог хаягдлын ажилтанд хүлээлгэн өгөх ажлыг хамтран гүйцэтгэх ба бохирдсон багаж хэрэгсэл, зөөлөн эдлэл, шилэн эдлэл зэргийг ариутгалд хүлээлгэж өгнө.

7.7 Түргэн тусламжийн жолоочийн үүрэг:

7.7.1.Монгол улсын замын хөдөлгөөний дүрэм болон холбогдох журам зааврыг баримтлан дуудлагын багийн аюулгүй байдлыг хангаж ажиллана.

7.7.2.Сарын дуудлагад үйлчлэх авто машины засвар үйлчилгээ, техникийн бүрэн бүтэн, бэлэн байдлыг хангасан байна.

7.7.3.Дуудлага хүлээн авснаас хойш дуудлага өгсөн газарт ажлын цагаар (08³⁰-15³⁰ цаг) хот орчимд 30 мин, ажлын бус цагаар (15³⁰-08³⁰ цаг) 1-2 цагийн дотор сарын дуудлагын багийн гишүүдийг авч дуудлагад гарна.

7.7.4.Халдвартай сэжигтэй сорьц материал тээвэрлэсний дараа тээврийн хэрэгсэлд халдваргүйжүүлэлт хийлгүүлж, 1-2 цагийн дараа цэвэрлэнэ.

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн
Захирлын албан үүргийг хавсран гүйцэтгэгчийн
2025 оны 11 дугаар сарын 20-ний өдрийн
А/74 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭНД СОРЬЦ ЦУГЛУУЛАХ
ИЖ БҮРДЛИЙН ЖАГСААЛТ

№	Шаардлагатай зүйл		Хэмжих нэгж	Тоо ширхэг	Тайлбар
1	Сорьц цуглуурах иж бүрдлийн цүнх		ш	2	
2	Хурдавчилсан тест (тарваган тахал, боом, холер, хумхаа г.м)		ш	10	өвчин тус бүрээр
3	1 удаагийн тариур (10, 20 мл)		ш	5	
4	1.5-2.0 мл-ийн эргэдэг тагтай сав		ш	5	
5	3% Иод		мл	100	
6	70% спирт		мл	100	
7	Ариун бамбар	хөвөн	ш	10	
		дакрон	ш	10	
8	Ариун хөвөн		ш	10	
9	Шархны лент		хайрцаг	1	
10	Ариун хуруу шил (хуванцар, шилэн)		ш	10-20	
11	Кэри-Блейр тээвэрлэх орчин		ш	10-20	
12	Фосфатын буфер		ш	10-20	
13	Физиологийн уусмал		ш	10-20	
14	Вакуумтейнерз үү	нил ягаан	ш	5	
		улаан	ш	5	
		шар	ш	5	
15	Мэс заслын хутга		ш	1	
16	Наац бэхжүүлэгч		мл	100	
17	Наацын шил		ш	10	
18	Наацын шилний хайрцаг		ш	1	
19	Парафильм		ш	1	
20	Спиртэн дэн		ш	1	
21	Сорьцын цуглуулах сав	Цэр цуглуулах	ш	5	
		Өтгөн цуглуулах	ш	5	
		Бөөлжис цуглуулах	ш	5	
		Шээс цуглуулах	ш	5	
22	Физиологийн уусмал		мл	100	
23	Хайч		ш	1	
24	Хямсаа		ш	2	
25	Чангалуур		ш	1	
26	Шилний харандаа		ш	1	
27	Шүдэнз		ш	1	
28	Хуруу шилний тавиур		ш	1	24 нүдтэй
29	Хурц үзүүртэй, иртэй хог хаягдлын сав		ш	1	
30	Гурван суурьт савлалтын иж бүрдэл		ш	1-2	

Тайлбар: Сорьц цуглуулах иж бүрдэл 2 ээлж байна.

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн
Захирлын албан үүргийг хавсран гүйцэтгэгчийн
2025 оныг 11 дугаар сарын 20-ний өдрийн
144 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

МЭРЭГЧ, АМЬТНЫ ДУУДЛАГЫН ХАЙРЦАГТ
БАЙХ ЭД ЗҮЙЛСИЙН ЖАГСААЛТ

№	Хэрэглэгдэх зүйлс	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1	Нэг удаагийн өмсгөл (комбинозон)	ш	2-3
2	Нэг удаагийн халад	ш	5-8
3	Нэг удаагийн малгай	ш	10-15
4	Нимгэн бээлий	хос	50
5	Амны хаалт	ш	20
6	Ажлын бээлий	хос	2
7	Амьтан тээвэрлэх гялгар уут	ш	50
8	Санитол	мл	200
9	Тарваганы хайч	ш	1
10	Зөөлөн хямсаа	ш	1
11	Корнцанг (том)	ш	1
12	Бикс (жижиг)	ш	1
13	Гарын цаас	боодол	1
14	Жавелион (0,03%)	шахмал	50
15	Хавх	ш	3
16	Занга	ш	5
17	Автомакс	ш	1
18	Денатурат спирт (70%)	л	0,5
19	Этилийн спирт (96%)	л	0,5
20	Тамедин	мл	2
21	Амьтан барих тор (дэгээ)	ш	1